

WorldSkills International

**ЁС ЗҮЙН ДҮРЭМ
БОЛОН БИЕЭ АВЧ
ЯВАХ СОЁЛ**



worldskills
Mongolia

Ёс зүйн дүрэм болон биеэ авч явах соёл
WorldSkills International

Ерөнхий мэдээлэл болон нөлөөлөл

Хамрах хүрээ

WorldSkills нь ур чадварын үнэ цэнийг харуулж, мэргэжлийн чадварлаг хүмүүсийг дэлхий даяар хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг дэмждэг.

Ур чадвар нь орчин үеийн амьдралын үндэс суурь юм. Бидний амьдардаг гэр орноос эхлээд бидний бүтээж буй нийгэм хүртэл чадварлаг мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн үр дүн юм.

Эдгээр чадварлаг мэргэжилтнүүд болон тэднийг төлөөлдөг сургалтын системүүд нь хувь хүний амжилттай яваа карьер, аж ахуйн нэгжийн тогтвортой байдал, цэцэглэн хөгжиж буй салбарууд болон улс орны эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь байдаг.

Дэлхийн эдийн засгийн энэ амжилт нь нийгмийн болон эдийн засгийн тогтвортой хөгжлөөс үүдэлтэй. WorldSkills нь дараах зургаан төвлөрсөн чиглэлээр хувь нэмэр оруулдаг:

1. Судалгаа
2. Ур чадвар сурталчлах
3. Карьер бий болгох
4. Боловсрол болон сургалт
5. Олон улсын хамтын ажиллагаа
6. Ур чадварын уралдаанууд.

WorldSkills нь гишүүд, албан тушаалтнууд, ажилтнууд болон хамтрагч түншүүд нь бидний хөдөлгөөнийг түгээж, нийгэм, эдийн засаг, соёлын янз бүрийн гарал үүсэлтэй оюутан, залуу мэргэжилтнүүдэд үлгэр дуурайлал үзүүлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг. WorldSkills-ийн гишүүн, хамтрагч түншүүд болох эсвэл хамтын ажиллагаа эхлүүлэх үед бүх хүмүүс болон байгууллагууд WorldSkills-ийн Ёс зүйн дүрэм болон биеэ авч явах соёл болох амьдралын үнэт зүйлс, бодлогыг хүндэтгэн дагаж мөрдөх ёстой.

- Ёс зүйн дүрэм нь WorldSkills-ийн үнэт зүйлс болон ёс суртахууны үндэс суурийг тодорхойлдог.
- Биеэ авч явах соёл нь ёс суртахуун бүхий зан төлөвийг байгууллагын өдөр тутмын ажилд хэрхэн хэрэгжүүлэхийг харуулдаг.

Энэхүү ёс зүйн дүрэм нь WorldSkills-ийн бүх үйл ажиллагаанууд болон хамтран ажиллагсад, гишүүд, сонирхогч талуудтай харилцах үндсэн стандартыг тогтоодог.

WorldSkills-ийн үйл ажиллагаа нь зургаан үндсэн чиглэлээр явагддаг бөгөөд тус бүр нь тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө, цаг хугацаатай байдаг.

Нөлөөлөл

Хөгжүүлэгчид шинэ баримт бичиг, бодлого, дүрэм журам болон уралдааны дүрмийг боловсруулж байх үед Ёс зүйн дүрэмд тусгасан агуулга, үзэл санаа болон үйл ажиллагааны стандартад нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллах.

Алсын хараа

Ур чадварын хүчээр дэлхийгээ сайжруулах.

Эрхэм зорилго

Мэргэжлийн ур чадвартай хүмүүсийн нэр хүндийг өсгөж, ур чадвар нь эдийн засгийн өсөлт, хувийн амжилтад ямар чухал болохыг харуулах.

Эзлэх байр суурь

Шилдэг ур чадварыг дэмжин хөгжүүлэх дэлхийн төв.

Ёс зүйн дүрэм

WorldSkills-ийн үнэт зүйлс, ёс зүйн үндэс, хэнд хамаарах вэ.

Үнэт зүйлсүүд ба ёс зүйн үндэс
WorldSkills-ийн үндсэн үнэт зүйлс:

- Шилдэг байдал
- Олон янз байдал
- Хүн бүрт тэгш хандах
- Инноваци
- Үнэнч шударга байдал
- Түншлэл
- Ил тод байдал

WorldSkills нь 65 жилийн түүхэндээ үнэт зүйлсэд суурилсан соёлоороо дамжуулан өндөр чанартай стандартыг эрхэмлэсэн шилдэг байдлыг нийгмийн бүх гишүүдийн амжилтын зорилго болгон хөгжүүлэхийг сурталчилж ирсэн.

Тиймээс бидний тавьсан стандарт нь WorldSkills-н брэнд болон үйл ажиллагааг нь дэмждэг эсвэл төлөөлдөг бүх хүмүүсийн хувьд байх ёстой үндсэн зүйл гэж үздэг.

Хамрах хүрээ

Энэхүү дүрэм нь WorldSkills-ийн дотоод, гадаад үйл ажиллагаануудад оролцдог хамтран ажиллагсад, гишүүд болон оролцогч талуудтай харилцахад хамаарна.

Ерөнхийд нь хэлбэл, WorldSkills-ийн Ерөнхий Ассамблей эсвэл ур чадварын уралдаанд албан ёсоор оролцох эрхтэй хүмүүс буюу Удирдах Зөвлөл, гишүүн төлөөлөгчид, албан ёсны ажиглагчид, ажиглагчид, ивээн тэтгэгч болон хамтрагч түншийн төлөөлөгчид, WorldSkills Champions Trust-ийн төлөөлөгчид, экспертүүд, багийн ахлагчид, орчуулагчид, уралдааны оролцогчид, сайн дурынхан, Захиргааны алба болон уралдаан зохион байгуулагчид, дараагийн уралдааныг санал болгох улсын болон гишүүдийн төлөөлөл, WorldSkills Foundation-ийн итгэмжлэгдсэн хүмүүсийг багтаана.

Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа, үүрэг

WorldSkills нь гишүүд болон хамтрагчдаасаа дараах баримт бичгүүдэд тодорхойлсон ёс зүй, биеэ авч явах соёлыг хүндэтгэн мөрдөхийг шаарддаг:

- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
www.un.org/en/universal-declaration-human-rights/
- Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Гэрээ
www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx
- Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Олон Улсын Гэрээ
www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CESCR.aspx
- ОУХБ-ын Хөдөлмөрийн Үндсэн Зарчим болон Эрхийн Тухай Тунхаглал
www.ilo.org/declaration/thedeclaration/lang-en/
- НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
<http://undocs.org/A/RES/70/1>
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн "HeForShe" кампанит ажил
www.heforshe.org/

Хүрээлэн буй орчин

Тогтвортой, эрүүл орчин нь хүн төрөлхтний амьдралын үндэс юм. WorldSkills нь бүх үйл ажиллагаандаа хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг багасгаж, зургаан төвлөрсөн чиглэлээр гишүүд болон хамтрагчидтай хамтран ажиллахдаа хүрээлэн буй орчны үнэт зүйлсийг үйл ажиллагаандаа нэгтгэн ажилладаг.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн

WorldSkills нь өсөн нэмэгдэж буй дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн гэдгээ хүлээн зөвшөөрдөг бөгөөд үүрэг хариуцлагаа ухамсартайгаар биелүүлэхийг хичээдэг. Гэвч зөвхөн өөрсдийн бүрэн хяналтандаа авсан газрууд дээр хариуцлагаа хүлээж чаддаг.

WorldSkills нь ижил үнэт зүйлс, өндөр стандартыг баримталдаг байгууллагуудтай холбоо

тогтоож, хамтран ажиллахыг эрмэлздэг бөгөөд үйл ажиллагаа явуулж буй бүх салбартаа бусдад нөлөөлөхийг хичээдэг.

Ёс суртахууны дүрэм журмууд

Бид байгууллагын өдөр тутмын ажилд ёс суртахууны зан төлөвийг хэрхэн сурталчилж, хэрэгжүүлэх вэ?

Танилцуулга

Энэхүү Ёс зүйн дүрэм нь WorldSkills нийгэмлэгийн соёл, нийгэм, эдийн засгийн олон янз байдлыг харгалзан манай дэлхийн хөдөлгөөний ёс зүй, зан төлөвийн тогтвортой тодорхойлолтыг өгдөг.

Хамрах хүрээ

Энэ дүрэм нь WorldSkills болон түүний брэндийг төлөөлж буй эсвэл холбоодыг төлөөлдөг бүх хүмүүст хамаарна.

Энэ нь Удирдах зөвлөл, Захиргааны алба, гишүүдийн төлөөлөл болон ажилтнуудад өдөр тутмын ажил үүрэг, хоорондын харилцаа, шийдвэр гаргахад нь чиглүүлэгч болохоос гадна бүх үйл ажиллагаа нь ёс зүйн зарчмуудад тулгуурласан байдаг.

WorldSkills-н хөдөлгөөн болон брэндийг төлөөлж буй бүх хүмүүс шударга байдал, хариуцлагын дээд стандартыг сахин биелүүлэх, байгууллагын үнэт зүйлс, ёс зүйн зарчмын дагуу ажиллах, эдгээр үнэт зүйлсийг цааш нь сурталчлан дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн байна.

Гишүүд болон тэдгээрийн төлөөлөгчид WorldSkills-н хөдөлгөөн, түүний үзэл санааг сонирхогч талуудад сурталчлахад онцгой үүрэгтэй гэдгээ ухамсарлах ёстой.

WorldSkills-ийн хөдөлгөөний хувьд ёс зүйн дүрмийн үнэ цэнэ нь хүн бүрийн эрх тэгш, ил тод байдал, шударга ёс, түншлэл, инновацийн соёлыг төлөвшүүлэх таатай орчныг бүрдүүлж, удирдан чиглүүлэх чадварт оршдог.

Байгууллагын ёс зүйн зарчим

Гишүүнчлэлийн байгууллагын хувьд бид бүх хувь хүн, улс орон, бүс нутаг, ашгийн болон ашгийн бус хэлбэрээр ажилладаг корпораци, байгууллагууд, засгийн газар, олон улсын байгууллагуудтай зөвхөн удирдах байгууллагаас тогтоосон бодлого, тэргүүлэх чиглэлийн дагуу хамтран ажиллах болно. Цаашилбал:

- Бидэнтэй хамтран ажилладаг бүх хүмүүс, улс орон, бүс нутагтай нээлттэй, шударга, хүндэтгэлтэй харилцаа тогтоох.
- Бид гишүүд болон хамтран ажиллагсдынхаа мэргэжлийн болон хувийн нууцын эрхийг хүндэтгэн, хүлээсэн үүргээ шударга, итгэл найдвартай, үр өгөөжтэй гүйцэтгэх болно.
- Улс төрийн бодлогын хувьд төвийг сахиж, аливаа бүлэглэлээс ангид байх.
- Маргааныг ил тод, бүтээлч байдлаар шийдвэрлэж, зөвхөн дэлхийн хөдөлгөөний ашиг сонирхолд нийцэж байвал мэдээллийг дэлгэнэ.
- Бидний үйл ажиллагаанд ямар ч хэлбэрийн дарамт, бэлгийн дарамтыг тэвчиж, авлига болон хээл хахууль авахыг хориглоно.
- Бид зөвхөн байгууллагын ашиг сонирхолд нийцсэн, асуудлыг чөлөөтэй, гүнзгий, бодитойгоор шийдвэрлэх чадварыг алдагдуулахгүй санхүүжилтийг хүлээн авна.
- Бид үнэт зүйлсэд тулгуурласан гүйцэтгэлийн соёлыг хөгжүүлж, хамтран ажиллагсадынхаа итгэлийг хүлээж, хадгалахыг эрмэлзэнэ.
- Бид шинэ бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад шууд нөлөөлж буй гишүүдтэй идэвхтэй зөвлөлдөнө.
- Бид хөтөлбөр эсвэл үйлчилгээ үзүүлэх амлалт өгөхдөө үнэнч шударга байдлын хамгийн өндөр стандартыг баримтална.

Практик удирдамж

Биеэ авч явах соёлын үндсэн стандарт

WorldSkills-н янз бүрийн ажил үүрэг гүйцэтгэдэг хүмүүс ихэвчлэн өөр өөр зан төлөв гаргадаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Дараах тодорхойлолтууд нь Удирдах зөвлөл болон Захиргааны

албаны гишүүд, итгэмжлэгдсэн ажилтнуудын бусдад үлгэр дууриал болох зан төлөвийн үндсэн стандартууд юм. WorldSkills болон WorldSkills-ийн брэндийг төлөөлж буй бусад бүх хүмүүс тухайн ажил үүрэг, нөхцөл байдалд нийцэн өөрсдийн зан төлөвийг чиглүүлэх үүрэг хүлээдэг. Гишүүд, оролцогч талууд болон хамтрагч түншүүд эдгээр зан төлөвийн стандартыг хэрэгжүүлж байгаа өөрсдийн нөхцөл байдлын талаар мэдээлэх ажлыг хөхүүлэн дэмждэг.

Удирдах зөвлөл ба гүйцэтгэх захирал

Удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх захирал нь олон нийтэд үйлчлэх стандартын хорооноос тодорхойлсон дараах 7-н зарчмыг дагаж мөрддөг.

1. Өөрийгөө зориулах (Selflessness):
Тэд WorldSkills-ийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, өөртөө, гэр бүл эсвэл найз нөхдөдөө санхүүгийн болон бусад ашиг олох үйлдэл хийхгүй.
2. Шударга байдал (Integrity):
Тэд албан үүргээ гүйцэтгэхэд нь нөлөөлж болзошгүй гадаад байгууллагаас санхүүгийн болон бусад хамааралтай үүрэг хүлээхгүй.
3. Объектив байдал (Objectivity):
Тэд WorldSkills-ийн холбоотой үйл ажиллагаа явуулахдаа (жишээлбэл, томилгоо хийх, гэрээ байгуулах) гавьяа зүтгэл, чадварыг үндэслэн сонголт хийдэг байх.
4. Хариуцлага (Accountability):
Тэд гаргасан шийдвэр, үйлдлийнхээ төлөө гишүүд болон оролцогч талуудад хариуцлага хүлээж, зохих хяналт, шалгалтад хамрагдана.
5. Ил тод байдал (Openness):
Тэд бүх шийдвэр, үйл ажиллагаандаа аль болох нээлттэй байх бөгөөд хувь хүний болон байгууллагын нууцлалд хохирол учруулахгүй бол шалтгааныг ил болгоно.
6. Үнэнч, шударга байдал (Honesty):
Тэд хувийн ашиг сонирхлоо тодруулж, зөрчил үүссэн тохиолдолд WorldSkills-ийн нэр хүндийг хамгаалж шийдвэрлэнэ.
7. Манлайлал (Leadership):
Дээрх зарчмуудыг манлайлал болон өөрсдийн жишээгээр үлгэрлэн үзүүлж, дэмжин хэрэгжүүлнэ.

Захиргааны алба

- Захиргааны албаны гишүүд хамтран ажиллагсад болон бусадтай харилцахдаа хүндэтгэлтэй хандаж, WorldSkills-н олон талт байдлууд болох соёлын гарал үүсэл, хүйс, бүс нутаг, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдлаас үл хамааран хүндэтгэлтэй, эрх тэгш хандах.
- Үүргээ үнэнчээр, үр дүнтэй гүйцэтгэхэд нь туслан дэмжиж, харилцан нээлттэйгээр зөвлөлдөн, ойлголцлын уур амьсгал бүрдүүлнэ.
- Хамтран ажиллагсдын хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж, нууцлалыг хамгаална.

WorldSkills нь Захиргааны албаны гишүүнд нөлөөлж болох аливаа шийдвэр гаргахын өмнө тухайн гишүүнтэй хангалттай зөвлөлдөх боломжийг хангаж ажиллана.

Итгэмжлэгдсэн ажилтнууд

WorldSkills нь тухайн гишүүн байгууллагаас томилогдсон хүмүүсийг үндэсний хариуцлага болон WorldSkills тэмцээн дэх багийн үр дүн, гүйцэтгэлд тулгуурлан ихэвчлэн сонгодгийг хүлээн зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч эдгээр хүмүүс нь ур чадварын уралдааны бэлтгэл ажил болон зохион байгуулалтыг уралдааны болон ёс зүйн дүрмийн дагуу шударга, хариуцлагатай, эрх тэгш байдлаар хандан, уралдааны оролцогч болон бусад итгэмжлэгдсэн хүмүүст анхаарал халамж тавьж ажилладаг нь тэдний өргөсөн тангарагт илэрхийлэгддэг.

Иймд томилогдсон эсвэл итгэмжлэгдсэн хүн нь Ёс зүйн дүрэм болон биеэ авч явах хэм хэмжээг зөрчиж, аливаа уралдааны үр дүнд нөлөөлөх эсвэл давуу тал олж авах оролдлого хийх нь зөвхөн өөрийн нэр хүндээр зогсохгүй тухайн баг, гишүүн улс/бүс нутаг болон WorldSkills-ийн нэр хүндэд хор уршиг учруулдаг.

Ийм зан төлөвийн байдал үзүүлэх нь тухайн хүний болон гишүүн байгууллагын одоогийн болон

ирээдүйн оролцоонд нөлөөлж, ноцтой үр дагавар учруулж болзошгүй. (Үр дагавар, хориг арга хэмжээ, шийтгэлийг үзнэ үү.)

Бусад биеэ авч явах зан төлөвийн элементүүд

- **Хуульд нийцэх байдал**

WorldSkills нь үйл ажиллагаа явуулж буй аль ч газар нутагт холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн байдлыг хангаж ажиллах ба ажилтнуудаа аливаа хууль, дүрмийг зөрчих эрсдэлийг багасгах зорилгоор зохих сургалтад хамруулдаг.

- **Бизнесийн шударга байдал**

WorldSkills нь нэр хүндтэй байгууллагын үүргээ биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй нийгэм, хамт олны өмнө хариуцлагатай ажиллана.

- **Санхүүгийн хараат бус байдал**

WorldSkills нь байгууллагын бие даасан байдал болон нэр хүндэд нөлөөлж болох санхүүжилтээс татгалзана. Энэ хүрээнд:

- Зөвхөн WorldSkills-ийн зорилго, үнэт зүйлсийг хуваалцдаг хандивлагчдаас санхүүгийн болон бусад дэмжлэгийг авна.
- Олон нийт, хувийн хэвшил, сан, буяны байгууллагууд болон хувь хүмүүсээс тэнцвэртэй байдлаар санхүүжилт олж авахыг эрмэлзэнэ.
- Өмнө дурдагдсан ангилал бүхий хандивлагчид болон спонсоруудыг хайж, хамтарч ажиллана.
- Санхүүжилт авахдаа байгууллагын зорилгод харш үйл ажиллагаа явуулахыг шаардах болзлыг хүлээж авахгүй.

Зочломтгой байдал, бэлэг, соёлын үнэт зүйлс болон авлигын эсрэг бодлого

WorldSkills нь “зочлох болон зочломтгой байдал” гэсэн нэр томъёо нь янз бүрийн соёлд өөр өөр утга илэрхийлж, өөр өөр байдлаар хэрэглэгддэгийг хүлээн зөвшөөрдөг. Хүлээн авалт, хоолны үйлчилгээ багтсан арга хэмжээ зохион байгуулахдаа WorldSkills нь зохион байгуулагч орны соёлыг хүндэтгэдэг боловч эдийн засгийн хэмнэлттэй, даруухан арга хэмжээ явуулахыг уриалдаг.

- WorldSkills нь урлагийн тоглолтын шилдэг бүтээлийг хүлээн зөвшөөрч, талархдаг ба энэ нь бидний арга хэмжээний үеэр үзүүлэхийг зорьдог шилдэг чанартай уялддаг. Бид оролцогчдын авьяас чадвар, амжилтыг тодотгоход анхаарсан арга хэмжээг дэмждэг бөгөөд үзэгчдийг тансаг эсвэл хэт чамин байдлаар үйлчлэхээс зайлсхийхийг зөвлөж байна.
- Түүнчлэн WorldSkills нь олон гишүүн орны соёлын харилцаанд бэлэг солилцох нь нөхөрсөг харилцаа тогтоох болон хоёр талдаа хүндэтгэл үзүүлэх чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Иймд, WorldSkills нь бэлэг солилцох үйл ажиллагаа нь хувь хүмүүсийн хоорондын нөхөрсөг харилцааг бий болгож, даруухан, хоёр талын соёлыг тусгасан байдлаар хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. Жишээлбэл, сургалтын үеэр экспертүүд хоорондын найрсаг харилцааг бэлгэдсэн жижиг бэлэг болон соёлын тэмдэг солилцохыг дэмждэг.
- Олон хүн цугларсан газар болон хурал, зөвлөлгөөнд оролцогчдод бөөнөөр бэлэг тараахыг идэвхтэй хориглодог.
- Өндөр үнэтэй бэлэг, тансаг зочломтгой байдал, хоол, аяллын ваучер болон байрлуулах амлалт зэрэг нь таалагдахыг оролдсон, эсвэл шийдвэр гаргалтад нөлөөлөх зорилготой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд хатуу хориглоно.
- WorldSkills нь Ёс зүйн дүрэм болон биеэ авч явах байдлын бүх элементүүдийг дагаж, өөрийн бүх үйл ажиллагаандаа шударга байдал, ёс зүйг чанд мөрдөхийг шаарддаг бөгөөд мөн харилцаж буй хамтрагч талуудаасаа ижил стандартуудыг хүлээдэг.
- WorldSkills нь авлигыг тэвчихгүй бөгөөд ямар ч хэлбэрийн хээл хахууль, бодит болон таамагласан аливаа үйлдлийг хориглодог.

Эрсдэлийн удирдлага ба мэдээллийн хамгаалалт

- WorldSkills нь үйл ажиллагааныхаа бүх салбарт эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлж, брэндийн нэр хүндийг хамгаалдаг.
- Мэдээллийн тогтвортой байдлын стандартыг хангаж, үйл ажиллагаа явуулж буй улс орнуудын холбогдох мэдээлэл хамгаалах зарчмуудыг дагаж мөрдөнө.

Үр дагавар, шийтгэл болон хориг арга хэмжээ

WorldSkills-ийн төлөөлөх хүмүүс энд заасан зан төлөвийн стандартыг санаатайгаар, урьдаас төлөвлөсөн, эсвэл илт зөрчсөн тохиолдолд төрөл бүрийн хориг арга хэмжээ болон шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Удирдлагын зөвлөл нь шууд болон албан тушаалтнаараа дамжуулан дараахь арга хэмжээг хэлэлцэж шийдэх болно:

- Хориг арга хэмжээ эсвэл шийтгэлийг тогтоох.
- Шийтгэл болон хориг арга хэмжээ үйлчлэх огноо болон хугацааг тодорхойлох.
- Шийтгэл болон хориг арга хэмжээний үргэлжлэх хугацааг тогтоох.

Албан тушаалтнууд ямар ч тохиолдолд "няцаашгүй нотлох баримт"-ыг үндэслэн шийдвэр гаргаж, ёс зүйн болон шударга ёсны зарчмыг удирдлага болгож ажиллана. Түүнчлэн хамтын хариуцлага болон хувь хүний шударга ёсыг тэнцвэржүүлэхэд үргэлж анхаарах болно.

Тухайн нөхцөл байдалд хэрэглэж болох олон янзын шийтгэл, хориг арга хэмжээнүүд байдаг. Хүрээнд багтаж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Олон төрлийн, янз бүрийн хориг арга хэмжээ эсвэл шийтгэлийг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлж болно. Дараах арга хэмжээнүүдийг авах ба үүгээр хязгаарлагдахгүй:

- Аман эсвэл бичгээр сануулга өгөх,
- Ур чадварын уралдаан, төрөл бүрийн арга хэмжээ, эсвэл Ерөнхий Ассамблейд оролцох эрхийг түр хугацаагаар хасах,
- Ур чадварын уралдаан, төрөл бүрийн арга хэмжээ, эсвэл Ерөнхий Ассамблейд оролцох эрхийг бүрмөсөн хасах,
- Гишүүн байгууллагад санхүүгийн торгууль ногдуулах,
- Гишүүнчлэлийн бүх эсвэл зарим хөнгөлөлт, эрхийг цуцлах,
- Саналаа өгөх үйл ажиллагаанд оролцох эрхийг хасах,
- Ноцтой тохиолдолд гишүүнчлэлийг цуцлах талаар Ерөнхий Ассамблейд санал гаргах. (Үндсэн Хууль 4.6-г үзнэ үү.)

Удирдах зөвлөл нь Ёс зүйн хороо эсвэл ижил төстэй хороог байгуулж, хориг арга хэмжээ эсвэл шийтгэлийн эрх мэдлийг шилжүүлэх, мөн тухайн хорооны эрх мэдлийн хүрээг санал болгох эрхийг тодорхойлж болно.

Одоогийн шүүх эрх мэдлийн хүрээ

- Уралдааны дүрэмтэй холбоотой зөрчлүүд: Ур чадварын уралдаантай холбоотой (сэжиглэгдсэн) дүрмийн зөрчлийг Уралдааны Хороогоор хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Уралдааны үеэр гарах ёс зүйн дүрмийн зөрчлүүд: Ур чадварын уралдаантай холбоотой боловч дүрэмд хамрагдаагүй (сэжиглэгдсэн) зөрчлүүдийг Сонсголын Хороогоор хэлэлцэнэ.
- Ёс зүйн дүрэм болон бусад зөрчлүүд: Ур чадварын уралдаан дээр боловч түүнээс гадуурх (сэжиглэгдсэн) зөрчлүүдийг Удирдах Зөвлөл эсвэл Ёс зүйн хороогоор хэлэлцэнэ.

Нэмэлт өөрчлөлт

Энэхүү баримт бичгийг Ерөнхий Ассамблейн чуулганы өмнө Удирдах Зөвлөл хянан шалгаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг чуулган дээр танилцуулж батлуулах санал гаргана.